

---

**Уул уурхайн салбарт бизнесийн шинэтгэлийг татварын  
бодлогоор дэмжих нь**

1. Оршил
2. Уул уурхайн салбарын өнөөгийн байдал
3. Бизнесийн орчны шинэтгэл уул уурхайн салбарт
4. Уул уурхайн салбарт үйлчилж буй татварын орчин
5. Татварын бодлогоор уул уурхайн салбарт шинэчлэл хийх нь
6. Дүгнэлт
7. Ашигласан материал

## 1. Оршил

Уул уурхайн салбар нь Монгол улсын төсвийн ... хувийг бүрдүүлдгээс гадна, ажил эрхлэлт, үйлдвэрлэлийн хэмжээгээр эдийн засагт чухал байр суурь эзэлдэг билээ. Эх орныхоо эрдэс баялгийг өгөөжийг ард түмнийхээ хүртээл болгох гол механизм нь татварын тогтолцоо билээ. Эрдэс баялгийнхаа ашиглалтаас ард түмэндээ хүртээх ойлголт, хэлбэрүүд эрдэс баялгийн юэц бүхий ихэнх орнуудад байдаг. Үүний нэг тод жишээ бол Кувейт улс юм. Кувейт улс нефтийн баялаг ихтэй бөгөөд түүний олборлолт, борлуулалтаас олсон орлогын нэлээд хэсгийг ирээдүйн иргэддээ зориулан хуримтлал болгон үлдээдэг талаарх мэдээллийг бид мэднэ.

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 он үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.10-д “Экспортын чиглэлтэй үйлдвэрлэл үйлчилгээ давамгайлсан, хувийн хэвшилд суурилсан эдийн засгийн нөхцлийн таатай орчин бүрдүүлэх экспортын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд татварын болон урамшууллын бодлогоор дэмжлэг үзүүлнэ” гэж заасан байдаг. Уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалтын татах, тухайн салбарт үйлчилж буй татварын орчныг боловсронгуй болгох ажлын үрээнд Ашигт малтмалын тухай хууль болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиудыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байна.

Энэхүү илтгэлийн эхний хэсэг нь уул уурхайн салбарын өнөөгийн байдал, бизнесийн орчны шинэтгэлийн жилийн үрээнд хийгдэж буй ажлуудыг хамарсан. Мөн илтгэлд уул уурхайн салбарын татварын орчны тухай болон Монгол улсын уул уурхайн салбар үйлчилж буй зарим татварын хуулийг боловсронгуй болгох саналыг дэвшүүлсэн байгаа.

## 2. Уул уурхайн салбарын өнөөгийн байдал

Уул уурхайн салбар нь Монгол улсын эдийн засагт чухал байр суурь эзэлдэг. Монгол улсын Засгийн газраас экспортын чиг хандлагатай үйлдвэрлэлийг дэмжих бодлого баримтласны үрээнд уул уурхайн салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон тодорхойлсон.

Тухайн салбар нь ажил эрхлэлтийн үвшин, үйлдвэрлэлийн хэмжээ, төсвийн орлогын бүрдүүлэлт зэргээр тэргүүлэх байр суурийг эзэлдэг. Тухайлбал, 2009 онд энэхүү салбарт үйл ажиллагаа явуулж буй Татварын ерөнхий газарт харъяалагддаг 24 аж ахуйн нэгжийн улсын төсөвт төлсөн татварын орлогын нийт дүн улсын төсвийн татварын орлогын 59%-ийг хувийг бүрдүүлсэн байна. 2010 оны 8 сарын байдлаар уул уурхай, олборлох салбарт ажиллагсадын тоо 17404 байсан ба энэ нь нийт үйлдвэрийн салбарт ажиллагсадын 33% юм. Энэхүү салбарын нийт үйлдвэрлэлийн хэмжээ 1 724 960.4 сая төгрөг бөгөөд энэ нь нийт аж үйлдвэрийн салбар дахь үйлдвэрлэлийн 69%-тай тэнцүү байна.<sup>1</sup>

Хүснэгт №1 – д уул уурхайн салбараас Монгол улсын эдийн засагт оруулж буй хувь нэмрийг 2002 – 2009 онуудаар харуулсан байна. Уул уурхайн салбараас Монгол улсын эдийн засагт оруулж буй хувь нэмэр өсч 2009 онд 2'704'877.8 сая төгрөгний нэмүү өртөг үйлдвэрлэсэн нь Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 28.2%, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 65,4 хувь, экспортын бүтээгдэхүүний 84.4 хувийг тус тус бүрдүүлсэн байна.

Хүснэгт№1

	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009
Дотоодын нийт бүтээгдэхүүний	10.1%	12.7%	17,3%	18.0%	30%	27.5%	28.2%	28.2%

<sup>1</sup> Статистикийн бюллетень, 2010 оны 8 сар

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний	47.3%	49.6%	64,7%	65,5%	72%	67.8%	64.3%	65.4%
Экспортын нийт бүтээгдэхүүний	56.7%	58.9%	70.8%	75,8%	67.9%	68.8%	80.7%	84.6%

Хүснэгт № 2 – т уул уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг 2004 – 2009 онуудын байдлаар харуулав. Сүүлийн 10 жилд алт олборлолт 17 дахин, зэс-молибдений үдэр олборлолт 30.4 хувь, хайлуур жоншны баяжмал үйлдвэрлэлт 14.6 хувиар тус тус өссөн. Манай улс 1995 онд 4.8 сая тонн нүүрс олборлож байсан бол 2009 онд 13.16 сая тонн нүүрс олборлож дотоодын хэрэгцээг бүрэн хангаад тодорхой хэсгийг нь экспортолж байна.

Хүснэгт № 2

№	Бүтээгдэхүүн	х/нэгж	2004	2005	2006	2007	2008	2009
1	Бүхэллэг жонш	мян.тн	206.7	233.4	239.4	245	219.1	344.2
2	Флотацын баяжмал	мян.тн	102.7	93.7	108.3	109.9	115.7	115.3
3	Баяжмал дахь зэс	мян.тн	130	126.3	129.7	130.2	126.8	129.8
4	Баяжмал дахь молибдени	тн	1141	1153	1403.9	1978.3	1783.6	2408.7
5	Цагаан тугалганы баяжмал /50%/	тн	22	47	-	27.5	87.5	15

6	Гянт болдын баяжмал /68%/	тн	77.1	78.2	182.2	244.5	141.9	38.6
7	Нүүрс	мян.тн	6665	7517.1	8074.1	9237.6	9691.6	13163.9
8	Алт/химийн цэврээр./	кг	18500	21900	21267	18087	15184	9803 бохир
9	Катодын зэс	тн	2376.1	2474.5	2618.4	3006.5	2586.6	2470.1
10	Төмрийн хүдэр	мян.тн	33.5	167.7	180	265.1	1387.4	1379.0
11	Цайрын баяжмал /чийгтэй/	мян.тн	-	22.8	109.9	154.7	143.6	156.5
12	Цувимал зэс	тн	-	195.5	221.2	-	-	-
13	Молибденийн исэл	тн	-	-	157.8	2664	2112.2	156.5

Өнөөдөр манай улсад 10 гаруй нэр төрлийн уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл явагдаж байгаа бөгөөд энэ нь ихэвчлэн анхан шатны боловсруулалт хийсэн баяжмал маягаар экспортод гарч байна.

Уул уурхайн салбарт түшиглэсэн эдийн засагтай монгол улсын хувьд бизнесийн орчны шинэтгэлийн жилийн хүрээнд уул уурхайн салбарыг татварын бодлогоор дэмжих асуудал их чухал болоод байна.

### 3. Бизнесийн орчны шинэтгэл уул уурхайд

Монгол Улсын Мянганөгжлийн 3 орилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын 5.1.5-д “Бизнесийн орчинг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ”, мөн 5.2.1-д “Өндөр технологит тулгуурлан стратегийн орд газруудыг ашиглаж, эдийн засгийн салбарын бүтцийг сайжруулан, мэдлэгт

суурилсан эдийн засгийг бий болгох, үндсэн чадамж, хуримтлалыг бүрдүүлнэ” гэж заасан тус тус заасан байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.10-д “Экспортын чиглэлтэй үйлдвэрлэл үйлчилгээ давамгайлсан, хувийн хэвшилд суурилсан эдийн засгийн өгжлийн таатай орчин бүрэлдэх экспортын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд татварын болон урамшууллын бодлогоор дэмжлэг үзүүлнэ” гэж заасан.
- “Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2009 оны 3 дугаар сарын 3-ны 22 дугаар тогтоолд Үйлдвэрлэлийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авах тухай заасан.

Энэхүү хөтөлбөр, бодлогын хүрээнд бизнесийн орчны шинэтгэлийн жилийн хүрээнд уул уурхайн салбарт дараах ажлууд хийгдэж байна. Үүнд:

- Шивээ-Овоогийн уурхайг шиглэн цахилгаан станц барих гэрээ хэлэлцээр байгуулах
- Зэс, цайр зэрэг төгөт металлын баяжмалыг гүйцээн боловсруулах үйлдвэрүүдийг эх орондоо байгуулах, металл тус бүрээр нь цэвэршүүлэн дотоод гадаадад борлуулах ажил агааг татвар, санхүүгийн бодлогоор дэмжих. Энэ ажлын хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ХХК -ийн зэсийн баяжмалд түшиглэсэн жилд 100 -120 мянган тонн зэс хайлуулах үйлдвэр байгуулах ажил хийгдэж байна
- Нөөц нь тогтоогдсон ашигт малтмалын орд газруудыг ашиглалтанд оруулах. Тухайлбал, Оюу толгойн зэс-алтны, Тавантолгойн үүрсний зэрэг томоохон бүлэг ордуудыг аж ахуйн эргэлтэд оруулах
- Одоо ажиллаж байгаа үйлдвэрүүд дээр технологийн шинэчлэл хийх, өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн гаргах тал дээр анхаарч 2015 он хүртэл зэс хайлуулах үйлдвэр, зэсийн хүдрийг уусган баяжуулж катодын зэсийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, молибдений баяжмалыг гүн боловсруулах, төмрийн хүдэр, түүний баяжмалыг боловсруулж металл

хийц үйлдвэрлэх, фосфоритийн бордоо үйлдвэрлэх, ураны ордоо ашиглан уран баяжуулах, цаашилбал эрчимч гарган авах нөхцөл боломжийг судлах, цахим техникийн зориулалттай газрын ховор элементийн ордуудаас эцсийн бүтээгдэхүүн гарган авах чиглэлээр ажиллах

Дээр дурдсан Оюу толгойн зэс-алтны, Тавантолгойн үүрсний зэрэг томоохон бүлэг ордуудыг аж ахуйн эргэлтэд оруулснаар Монгол Улсын эдийн засгийн өсөлтөнд томоохон өөрчлөлт гарах бөгөөд эдгээр ордуудын дэд бүтцийн асуудал шийдэгдсэн үед Цагаан суврага, Хармагтайн зэсийн ордуудыг ашиглах боломж нээгдэнэ. Ингэснээр зэрэг, эрчим хүчний томоохон экспортлогч улс болох боломж бүрдэх юм.

Сэлэнгэ, Дарханы районд байгаа төмрийн хүдрийн ордуудаас хүдэр олборлон ангижруулах, ангижруулсан төмрийн зарим хэсгийг Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрт нийлүүлэх, үүний тулд технологийн шинэчлэл, өөрчлөлт хийж өргөтгөснөөр төмөр эдлэл дотооддоо үйлдвэрлэх хэмжээг нэмэгдүүлэх, төмрийн баяжмал болон ган үйлдвэрлэн экспортлох боломжтой болно.

Таван толгой, Нарийн Сухайтын үүрсний бүлэг ордуудыг түшиглүүлэн нүүрс боловсруулах, баяжуулах үйлдвэрүүдийг байгуулан олон улсын зах зээлийн стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх экспортлох боломжтой.

Уул уурхайн салбарт хийгдэж байгаа болон цаашид хийгдэх дээр дурдсан ажлуудыг татварын бодлогоор дэмжих болон энэхүү салбарт гадны хөрөнгө оруулалтыг татах татварын орчин бүрдүүлэх асуудал чухал болоод байна.

#### **4. Уул уурхайн салбарт үйлчилж буй татварын орчин**

Ул орныхоо эрдэс баялгийн үр өгөөжийг ард түмнийхээ хүртээл болгох чухал арга хэрэгслүүдийн нэг нь татварын тогтолцоо билээ. Аль ч улсын уул уурхайн татварын тогтолцоонд эрдэс баялгийн салбарт ашигт малтмалын хайгуул хийх, ордуудыг үйлдвэрлэл, ашиглалтын эргэлтэд оруулах, байгаль

орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, нөхөн сэргээлтийг анхны хэлбэрт нь үрсэн түвшинд хийх хөрөнгө оруулалтыг энэхүү салбарт татах, үүний зэрэгцээ нийгэм, ард түмэнд ээ энэхүү салбараас орох ашиг, үр өгөөжийг хүртээх зорилгыг тавьдаг. Эрдэс баялгийн үйлдвэрлэлд хөрөнгө оруулагчдад татварын дарамт үзүүлэх бол хөрөнгө оруулалтын олдоц бага байна, харин татварын хувь хэмжээ бага бол шавхагдах эрдэс баялгийн ашиглалтаас төрийн санхүүгээр дамжин ард иргэдийн хүртэх орлого бага байх болно. Иймд төр засгийн болон хөрөнгө оруулагч компаниудын ашиг сонирхлыг уялдуулсан татварын бодлого нэн чухал билээ.

Уул уурхайн салбар нь асар их хөрөнгө оруулалтыг шаардаж байдаг ба энэ хэмжээгээрээ их хэмжээний эрсдлийг дагуулж байдаг өөрөөр Иймд хөрөнгө оруулагчдын хувьд татварын орчин тогтвортой байх нь чухал асуудлуудын нэг юм.

Энэхүү салбарт хөрөнгө оруулах гэж буй компаниуд нь олон улс орнуудаас геологийн потенциал, татварын орчин, улс төрийн тогтвортой байдал зэргийг нь харгалзан сонголт хийдэг. Нэг компанийн хөрөнгө оруулалтын шийдвэрт голлох байр суурь эзлэх аливаа нөхцөл зүйлс өөр нэг компанийн хувьд хоёрдогч нь байж болох талтай тул компаниудын хувьд эдгээр үчин зүйлсийн нөлөөлөл янз бүр байдаг байна<sup>2</sup>. Уул уурхайн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтын талаар судалгааг Колорадогийн Их Сургуулийн профессор Жеймс М. Отто гардан хийсэн байна. Энэхүү судалгаа нь улс орнуудын өөрийн улсын эрдэс баялгийн салбарын хөрөнгө оруулалтын өрсөлдөх чадварыг үнэлж дүгнэх стандарт аргачлал болоод зогсохгүй хөрөнгө оруулагч компаниудын хувьд хөрөнгө оруулалт хийхэд анхаарах үчин зүйлсийн талаар чухал мэдээлэл болжөгсөн. Энэхүү судалгаагаар хөрөнгө оруулалтын шийдвэрт нөлөөлөх нийт 60 үчин зүйлсийг гаргасан ба эхний 20 үчин зүйлсийг хүснэгт № 3 – т харуулав. Үчин зүйлсийг ач холбогдлоор нь нэгээс эхлэн жагсаасан байна.

<sup>2</sup> James M. Otto, "Competitive position of Mongolian mineral sector fiscal system: the case of model copper mine", January 2007.

Хайгуулын шат	Олборлолтын шат	Хөрөнгө оруулалтын шийдвэрт нөлөөлөх хүчин зүйл
1	-	Тухайн эрдсийн геологийн потенциал
-	3	Ашгийн түвшин
2	1	Лицензийн баталгаат байдал
3	2	Ашгаа шилжүүлэх боломж
4	9	Уул уурхайн тууштай бодлого
5	7	Компанийн удирдлагын хяналт
6	11	Эрдэс баялгийн өмчлөлийн асуудал
7	6	Гадаад валютын зохицуулалт
8	4	Олборлолт, ашиглалтад тавигдах тууштай нөхцлүүд
9	5	Татварын үүрэг хариуцлагыг урьдчилан тодорхойлох боломж
10	8	Байгаль орчны үүрэг хариуцлагыг урьдчилан тодорхойлох боломж
11	10	Санхүү, татварын орчны тогтвортой байдал
12	12	Гадны санхүүжилт олох боломж
13	16	Тухайн улсын урт хугацааны тогтвортой байдал
14	17	Эрдэс баялгийн хөгжсөн тогтолцоо
15	-	Геологийн арга техникийг хэрэглэх боломж
16	13	Татвар ногдуулалт ба татварын хувь хэмжээ
17	15	Импорт, экспортын бодлого
18	18	Компанийн эзэмших нийт хувьцаа
19	21	Эзэмшлийн хувиа бусдад шилжүүлэх эрх

20	20	Тухайн улс дахь дотоодын зөрчилдөөн
21	14	Хилийн чанадад данс, тооцоотой байх боломж
22	19	Орчин үеийн уул уурхайн эрх зүйн тогтолцоо, хууль тогтоомж

Судалгаанаас харахад эхний 20 чухал үзүүлэлтүүдийн 4 нь татвартай холбоотой байна. Иймд уул уурхайн салбарыг хөгжүүлэхэд татварын зөв бодлогоор уул уурхайн салбарын онцлогийг тусгасан татварын тогтолцоо бүрдүүлэх нь чухал асуудал юм. Аль улс орны хувьд уул уурхайн салбарын татварын орчныг үрдүүлэхэд тулгарч буй асуудлуудын нэг бол тухайн салбарыг бусад салбараас хир зэрэг онцолж үзэх вэ гэдэгт оршдог.

Уул уурхайн салбар нь бусад салбарыг бодвол циклийн ажиллагаатай. Өөрөөр хэлбэл, хайгуулын, олборлолтын, ашиглалтын үе шатууд болон уурхайг хаах үе шатыг дамжин эрдэс баялгийн салбарт өрсөнгө оруулсан компаниуд үйл ажиллагаагаа явуулна.

Англо Американ компани уурхайн ажиллагааны шат тус бүрт төлөх татварын судалгааг гаргасан байна. Хүснэгт №3-т уурхайн ажиллагааны шат тус бүрт төлөгдөх татварын төрлүүдийг харуулав<sup>3</sup>.

Уурхайн ажиллагааны явцад төлөх татварууд

Уурхайн ажиллагааны шат	Ашигт ажиллагааны байдал	Төлөх татварын төрөл
Хайгуулын шат	Алдагдал	ХХОАТ, шууд бус татварууд, бэлтгэн нийлүүлэгчдийн төлөх татвар
Хөгжүүлэлтийн шат	Алдагдал, капитал	ХХОАТ, шууд бус

<sup>3</sup> Англо Американ компаний 2008 онд олон нийтэд гаргасан судалгаа

	оруулалт	татварууд, бэлтгэн нийлүүлэгчдийн төлөх татвар
Эхэн үеийн үйлдвэрлэл	Алдагдлаа нөхөх	ХХОАТ, шууд бус татварууд, бэлтгэн нийлүүлэгчдийн төлөх татвар, ашигт малтмалын өөц н ашигласны төлбөр
Үйлдвэрлэлийн шат	Цэвэр ашиг	ХХОАТ, шууд бус татварууд, бэлтгэн нийлүүлэгчдийн төлөх татвар, ашигт малтмалын өөц н ашигласны төлбөр, орлогын албан татвар
Уурхайг хаах шат	Алдагдал	ХХОАТ, шууд бус татварууд, бэлтгэн нийлүүлэгчдийн төлөх татвар

**Хайгуулын үе шат** хамгийн эрсдэлтэйд тооцогдох ба энэ эрд орлого олох боломжгүй тул гарсан зардлыг ирээдүйн татвар ногдох орлогоос суутгах асуудал тавигдана. Улс орнууд эрдэс баялгийн салбар өрөнгө оруулсан компаниудын цаашдын уурхайн ашиглалтын үе шатыг дэмжих үүднээс тухайн хугацаанд хуримтлуулсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох зохицуулалт хийдэг. Манай улсын Ашигт малтмалын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт зааснаар “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг зөвшөөрлөөр олгогдсон тайлбад хийсэн хайгуулын ажлын болон уурхайн эдэлбэрийг ашиглалтад бэлтгэсэн зардлыг үйлдвэрлэл эхэлснээс хойш 5 жилийн хугацаанд тогтмол

хэмжээгээр үйлдвэрлэлийн зардалд оруулж, шимтгэлийн сан байгуулна” гэж заасан байдаг. Гэвч Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулинд зөвхөн ашиглалтын тусгайөвшөөрөл эзэмшигчийн уг зөвшөөрлийг эзэмших, шилжүүлэх, талбайг шилжүүлэн авахтай холбогдон гарсан зардлыг тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаанд үйлдвэрлэлийн зардалд оруулж, шимтгэлийн сан байгуулна гэж заасан байдаг учраас хайгуулын ажлын зардалтай холбоотойгоор хугацааны хувьд практикт маргаанүүсэх асуудал олонтаа гардаг.

Алдагдлыг шилжүүлэн тооцох тухай Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20 дугаар жилийн 20.2 хэсэгт заасны дагуу уул уурхайн салбарын хувьд алдагдлыг гарсан татварын жилийг нь дараалсан 4 – 8 жилийн хугацаанд татвар ногдуулах орлогоос хасч тооцох ба хасагдах алдагдлын хэмжээ тухайн жилийн татвар ногдуулах орлогонд 100% - иас хэтрэхээргүй байна гэж заасан нь уул уурхайн салбарын онцлогийг харгалзан олон улсын практикт нийцсэн хуулийн зохицуулалт юм.

**Уурхайн хөгжүүлэлтийн шатанд** уурхайн ажиллагааг эхлүүлэхийн тулд олон төрлийн тоног төхөөрөмж худалдан авч суурилуулах шаардлагатай байдаг ба эдгээр тоног төхөөрөмжүүдийн ихэнхийг гаднаас импортлодог байна. Ихэнхи улс орнууд тоног төхөөрөмжид хурдавчилсан аргаар элэгдэл байгуулахыг зөвшөөрч зардлаа хурдан нөхөх боломж олгодог.

Уурхайн үйл ажиллагааны хамгийн урт хугацааны бөгөөд ашигт ажиллагаа өндөртэй үе нь **үйлдвэрлэлийн үе шат** юм. Ашигт ажиллагаа нь дэлхийн зах зээл дэх үүхий эдийн үнээс ихээхэн хамаардаг тул улс орнууд экспортын татварын хөнгөлөлт олгодог байна.

Эрдэс баялгийн ашиглалтын өөц дуусч уурхай зогсох тул энэ үед орлого байхгүй харин **уурхайг хаах**, уурхайн талбайд нөхөн сэргээлт хийх зэрэг өндөр хэмжээний зардал гардаг. Үүнтэй холбоотойгоор ихэнхи улс орнууд уул уурхайн компаниудын үйлдвэрлэл явуулж байх хугацаандаа байгуулсан тусгай зориулалтын сангийн хөрөнгийг татвар ногдох орлогоос хасах хуулийн

зохицуулалт хийдэг байна. Зарим нэг нь уурхайн талбайд юхөн сэргээлт хийх нь тухайн уул уурхайн ашиг олсон компаний нийгмийн хариуцлага түүнтэй холбоотой зардлыг татвар ногдох орлогоос хасахыг эсэргүүцдэг байна.<sup>4</sup>

Өнөөдөр манай улсын уул уурхайн салбарт үйлчилж буй татварын тогтолцоонд дараах төрлийн татваруудыг хамруулдаг. Үүнд:

- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
- Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр
- Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
- Гаалийн албан татвар
- Нэсэгдсэн өртгийн албан татвар
- Хувь хүний орлогын албан татвар
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар
- Онцгой албан татвар
- Ус рашаан ашигласны төлбөр
- Газрын төлбөр
- Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
- Бусад татвар, төлбөр, хураамжууд

Эндээс харахад энэхүү салбарт бусад салбартай харьцуулахад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар, лицензийн төлбөр оногдохоос гадна зарим татвар, төлбөрүүдийг илүү өндөр хувиар ногдуулдаг.

Өнөөдрийг хүртэл уул уурхайн салбарт тэргүүлэх байр эзэлдэг Эрдэнэт үйлдвэрийн улсын төсөвт төлсөн татварын орлогын дүн нь Монгол Улсын нийт татварын орлогын 2009 онд 33 хувийг, 2010 онд 43 хувийг бүрдүүлж байна. Мөн УТОХГ-ын харьяа уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг 23-24 аж ахуйн нэгжийн

<sup>4</sup> Paul Mitchell, "Taxation and investment issues in mining"

улсын төсөвт төлсөн татвар нь Монгол улсын нийт татварын орлогод эзлэх хувь нь 2009 онд 59 хувь, 2010 онд 63 хувьтай байгаа нь томоохон үзүүлэлт юм. Иймд тухайн салбарыг татварын бодлогоор дэмжих шаардлагатай байна.

#### **5. Татварын бодлогоор уул уурхайн салбарт шинэчлэл хийх нь**

Уул уурхайн салбарыг татварын бодлогоор дэмжихэд татварын орчинг боловсронгуй болгох нь нэн тэргүүний асуудал бөгөөд өнөөдөр үйлчилж буй татварын эрх зүйн актуудыг илүү боловсронгуй болгох шаардлагатай байна.

Иймд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

##### **а. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувьд**

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, эл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож ногдуулж байгаа. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 47 зүйлийн 47.2 хэсэгт борлуулалтын үнэлгээг тооцох журмыг заасан байна. Мөн хуулийн 47 зүйлийн 47.3 хэсэгт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг дотоодод борлуулж буй үүрс болон түгээмэл тархацтай ашигт малтмалын хувьд борлуулалтын үнэлгээний 2.5% -тай, бусад ашигт малтмалын хувьд борлуулалтын үнэлгээний 5%-тай тэнцэнэ.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг борлуулалтын үнэлгээнээс нь хамааруулж өсөн нэмэгдэх хувьтай болгох асуудал яригдаж байгаа. Энэ тохиолдолд борлуулалтын үнийн шатлалыг инфляцийн хувьтай тохируулах шаардлагатай юм.

Хуулинд заасан борлуулалтын үнийг тооцох аргачлалыг илүү тодорхой болгох шаардлагатай байна. Тухайлбал, Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.3 хэсэгт заасны дагуу дотоод, гадаадын зах зээлд борлуулсан бүтээгдэхүүний зах зээлийн жишиг үнийг тодорхойлох боломжгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдүүлсэн борлуулалтын орлогыг

үндэслэнэ гэж заасан байдаг. Гэтэл харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хооронд хийгдсэн борлуулалтын үед үнэ шилжилтийг зохицуулахад татварын албанаас борлуулалтын үнийг шууд бус аргаар тодорхойлох тухай заалт байхгүй байна. Иймд энэ хуулинд харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хооронд хийгдсэн борлуулалтын үед харилцан хамааралгүй этгээдүүдийн хооронд хийгдсэн бодитүнийг үндэслэнэ гэж өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

#### b. Орлогын албан татварын тухайд

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу 11үдээр зүйлд заасны дагуу харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хооронд хийгдсэн ажил, үйлгээний татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гүдүний жишиг үнэ хэрэглэх аргачлалыг үндэс болгохоор заасан байдаг. Уул уурхайн салбар жгжиж, гадаадын хөрөнгө оруулалт ихээр хийгдэж байгаөнөө үед Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулавдчлөлт оруулж харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хооронд хийгдсэн ажил гүйлгээний татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо ЭЗХАХБ-аас гаргасанүнэ шилжилтийг тооцох аргачлалыг үндэс болгох нь зүйтэй юм.<sup>5</sup>

Мөн хуулийн 6 дугаар зүйлд зааснаар “харилцан хамаарал бүхий этгээд” гэж тухайн компаний хувьцааны, ашиг хуваарилалтын тодорхой хувийг эзэмшдэг, удирдлагынх нь тодорхой хувийг томилох эрхтэй, үйл ажиллагааных нь бодлого чиглэлийг тодорхойлдог этгээдийг хэлж байгаа. Гэтэл энүж тодорхойлолтод нэг толгой компаний охин компаниудыг хамруулжүззэгүй байна. Тухайлбал, А компани С ба Б компаниудын 50-иас дээш хувийг эзэмшдэг бол А ба С компаниуд, А ба Б компаниудыг харилцан хамааралүхий этгэдүүд гэж үзэх бөгөөд С ба Б компаниудыг харилцан хамаарал бүхий компаниуд гэж үзэхгүй байна. Иймд хуулинд нэг толгой компаний харьяа аж ахуйдийнүгж харилцан хамаарал бүхий этгээд гэж үзэх хуулийн заалт оруулах нь зүйтэй юм.

<sup>5</sup> “The fiscal regime for mining – a way forward”, IMF report, 2010.

Хуулийн 14 үдээ р үйлд нимгэн капиталжуулалтын тух ай тусгасан байна. Энэхүү заалтын дагуу өрөнгө оруулагчаас аж ахуйн нэгжид олгосон зээл нь оруулсан өрөнгийнх нь гурав дахинаас илүү гарсан бол, илүү гарсан зээлд төлсөн хүүгийн зардлыг татвар ногдох орлогоос хасахгүй гэж заасан боловч тухайн аж ахуйн нэгжээс өрөнгө оруулагчид олгосон зээлийн хүүгийн зардалд хязгаарлалт хийгдээүй байна. Иймд хуулинд харилцан хамааралгүй этгээдүүд гэдэг ойлголтыг нилээнөргөн хүрээнд авч үзэхээс гадна, охин компаниудын хоорондын зээл, охин компаниас толгой компанид олгосон зээлийн хүүгийн татвар ногдох орлогоос хасахд хязгаарлалт тогтоож өгөх шаардлагатай юм.

## 6. Дүгнэлт

Үр ашигтай татварын тогтолцоо бол эрдэс баялгийн салбарт ашигт малтмалын хайгуул хийх, ордүйлдвэрлэл, ашиглалтын эргэлтэд оруулах байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх нөхөн сэргээлтийг анхны хэлбэрт нь хүрсэн түвшинд хийх боломж олгохын зэрэгцээ байгалийн баялгаа ашигласны төлөө улс орныхоо иргэдэд үндэслэл нь тодорхой ойлгомжтой, хуваарилалтын шударга зарчмыг хангахад чиглэгдэх учиртай.

Эрдэс баялгийнүйлдвэрлэлд хөрөнгө оруулагчдад татварын ихээхэн дарамт үзүүлэхээр бол хөрөнгө оруулалтын олдоц бага байх нь зүй ёсны хэрэг. Татвар дэндүү доогуур бол шавхагдах эрдэс баялгийн ашиглалтаас төрийн санхүүгээр дамжин ард иргэдийн хүртэх орлого эрсдэлд орох талтай.

Уул уурхайн салбартүйлчилж буй татварын орчинг тогтвортой байлгах, нөгөөтэйгүүр татварын зохицуулалтыг боловсронгуй болгох нь тухайн салбарыг хөгжүүлэхэд гадаадын хөрөнгө оруулалтыг татах, хязгаарлагдмал баялгийг үр дүнтэйгээр ашиглахад маш чухал юм.

Уул уурхайн салбарт хөрөнгө оруулахад нөлөөлөх гол үзүүлэлтүүдийн эхний дөрөв нь татвартай холботой байна.ММ Монгол улсын төсвийн орлогын дийлэнх хэсгийн бүрдүүлж буй энэхүү салбарыг хөгжүүлэхэд татварын бодлого чухал ач холбогдолтой билээ. Иймд тухайн салбарын татварын орчныг зохицуулж буй Ашигт малтмалын тухай хууль болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиудыг боловсронгуй болгох шаардлагатай юм.

Ашигласан материал:

1. Монгол улсын албан татварын хуулийн эмхтгэл
2. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
3. Статистикийн бюллетень, 2010 оны 8 сар
4. СТ-23 мэдээ 2009, 2010 он
5. James M. Otto, "Competitive position of Mongolian mineral sector fiscal system: the case of model copper mine", January 2007.
6. Англо Америк компаний 2008 онд олон нийтэд гаргасан судалгаа
7. Paul Mitchell, "Taxation and investment issues in mining"
8. "The fiscal regime for mining – a way forward", IMF report, 2010